



ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ
ДАРГА О.ЧУЛУУН ТАНАА

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

2020.11.17 № 05/12774
танай _____ -ны № _____ -т


Хувийн ашиг сонирхлын урьдчилсан
мэдүүлэг хянасан тухай

Үндэсний геологийн албаны Геологийн судалгааны хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Сосорбарамын Батмөнх, Гео-мэдээллийн төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Цогтсайханы Минжинсор, Геологийн баримтын төв архив хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Рэнцэндоржийн Энхсайхан, Эрдэс баялгийн судалгаа, төлөвлөлт, эдийн засгийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Гомбосүрэнгийн Алтанхуяг, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилогдохоор нэр дэвшсэн Сонгиноогийн Шинэ-Од нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Харин нэр дэвшигч Г.Алтанхуягийн хамаарал бүхий этгээд болох эхнэр А.Оюунзул нь ашигт малтмалын хайгуул хийх, уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх, гадаад худалдааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх "Гео актив" ХХК-ийн гүйцэтгэх захирал, уул уурхайн чиглэлээр зөвлөгөө өгөх, гадаад худалдаа, геологийн тойм судалгааны чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх "Орд актив" ХХК-ийн захирлаар тус тус бүртгэлтэй байх тул тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж ажиллах нь зүйтэй.

Цаашид Монгол Улсын Их Хурлын 2016 оны 51 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг гаргах, хянах үйл ажиллагааг цахим хэлбэрт бүрэн шилжүүлсэн тул мэдүүлгийг тус газарт цахимаар ирүүлж байхыг үүгээр мэдэгдье.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ОРЛОГЧ
БӨГӨӨД ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН АЛБАНЫ
ДАРГА, АХЛАХ КОМИССАР



Л.СҮХ-ОЧИР

0019180